



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Баяндэлгэр сумын ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: СБА-2022/88/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:

www.audit.mn

Баруун-Урт сум

2022 он

Дарга,

тэргүүлэх аудитор:

М.Нарантуяа

Утас: 99029193 Цахим хаяг: narantuyam@audit.gov.mn

Аудитын менежер:

Г.Даваа

Утас: 99035990 Цахим хаяг: davaag@audit.gov.mn

Ахлах аудитор:

С.Ариунбаяр

Утас: 99076224 Цахим хаяг: ariunbayars@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	4
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	4
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	5
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	6
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	7
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	8
2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн төсвийн гүйцэтгэлийн тайлан	9
3. Аудитын тайлан.....	10
3.1 Ерөнхий зүйл.....	10
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт	10
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	11
3.4 Материаллаг байдал	11
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга	11
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	12
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг	12
3.8 Аудитын гол асуудал	13
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	13
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт.....	13
3.10 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	13
4. Аудитын илрүүлэлт	13
4.1 Албан шаардлага	13
4.2 Зөвлөмж.....	14
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	15

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
НА	Нотлох ажил
НББ	Нягтлан бодох бүртгэл
СТА	Санхүүгийн тайлангийн аудит
ТШЗ	Төсвийн шууд захирагч
ЭЕШ	Элсэлтийн ерөнхий шалгалт



**СҮХБААТАР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

22000 Баруун-Урт сум, Сүхбаатар аймаг
Утас: 70518396, Факс: 70518396
E-mail: Sukhbaatar@audit.gov.mn

Ауд. 02.25 № 70
танай _____-ны № _____-т

СҮХБААТАР АЙМГИЙН БАЯНДЭЛГЭР
СУМЫН ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН
СУРГУУЛИЙН ЗАХИРАЛ
Т.МАЖИГСҮРЭН ТАНАА

АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Сүхбаатар аймгийн Баяндэлгэр сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан алдаа, зөрчлийн үр нөлөөг эс тооцвол Сүхбаатар аймгийн Баяндэлгэр сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Төсвийн хөрөнгөөр тавилга, тоног төхөөрөмж худалдан авч Засгийн газрын 2021 оны 43 тогтоолоор баталсан хэмнэлтийн журмыг зөрчсөн, бодитоор байхгүй аж ахуйн материал бүртгэсэн, нягтлан бодогч дансны хуулгыг нягтлан үзээгүйгээс бодит бус өглөг үүсгэсэн зэрэг зөрчлүүд нь Төсвийн, Нягтлан бодох бүртгэлийн, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль болон тайлант хугацааны ажил гүйлгээний анги, дансны үлдэгдлийн холбогдох тодруулгын тохиолдсон байх, иж бүрэн байх, үнэлгээ ба хуваарилалт, тасалбар болголт, оршин байх, эрх ба үүрэг зэрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



М.НАРАНТУЯА

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>95,157,350.00</u>	<u>97,540,644.69</u>
35	БАРАА МАТЕРИАЛ	95,157,350.00	97,540,644.69
351	Түүхий эд материал	1,575,000.00	1,962,000.00
35130	Эм боох материал	1,575,000.00	1,962,000.00
354	Хангамжийн материал	93,582,350.00	95,578,644.69
35410	Бичиг хэргийн материал	1,292,000.00	2,723,061.91
35420	Аж ахуйн материал	70,998,650.00	74,948,856.86
35440	Түлш, шатах тослох материал	634,000.00	757,525.92
35460	Хүнсний материал	3,508,500.00	00.00
35470	Бусад хангамжийн материал	17,149,200.00	17,149,200.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>2,637,587,193.08</u>	<u>2,601,377,555.92</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	2,637,587,193.08	2,601,377,555.92
392	Биет хөрөнгө	2,585,644,193.08	2,549,494,555.92
39201	Барилга, байгууламж, орон сууц	2,736,816,047.69	2,736,816,047.69
39202	Хуримтлагдсан элэгдэл	-340,402,107.36	-422,156,948.04
39203	Авто-тээврийн хэрэгсэл	33,410,000.00	33,410,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-16,445,000.02	-20,215,000.06
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	272,496,466.00	304,621,818.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	-219,228,106.14	-244,783,219.62
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	185,447,242.00	215,521,242.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	-123,830,349.91	-145,839,325.18
39214	Бусад үндсэн хөрөнгө	36,610,133.00	73,510,133.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	-17,337,638.18	-24,340,846.94
39217	Ном	38,107,506.00	42,950,655.07
393	Биет бус хөрөнгө	51,943,000.00	51,883,000.00
39301	Програм хангамж	1,050,000.00	1,050,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-845,000.00	-905,000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	51,738,000.00	51,738,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>2,732,744,543.08</u>	<u>2,698,918,200.61</u>
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	<u>00.00</u>	<u>21,913,462.38</u>
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	00.00	21,913,462.38
413	Өглөг	00.00	21,913,462.38
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	00.00	8,990,093.52
4136	Бусад өглөг	00.00	12,923,368.86
41361	Байгууллагад төлөх өглөг	00.00	12,923,368.86
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>2,732,744,543.08</u>	<u>2,677,004,738.23</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	2,732,744,543.08	2,677,004,738.23
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	463,183,325.29	463,183,325.29
51101	Өмч: - төрийн	463,183,325.29	463,183,325.29
512	Хуримтлагдсан үр дүн	1,980,458,566.55	1,924,718,761.70
51210	Өмнөх үеийн үр дүн	1,980,458,566.55	1,980,458,566.55
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	-55,739,804.85
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	289,102,651.24	289,102,651.24
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>2,732,744,543.08</u>	<u>2,698,918,200.61</u>

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон			/төгрөгөөр/
Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	1,556,651,260.50	1,637,093,826.84
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	34,715,360.50	93,680,421.84
120	Нийтлэг татварын бус орлого	34,715,360.50	93,680,421.84
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	34,715,360.50	93,680,421.84
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	34,715,360.50	93,680,421.84
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	109,725,600.00	101,760,305.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	1,412,210,300.00	1,441,653,100.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	6,911,000.00	7,442,805.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	00.00	1,700,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	6,911,000.00	5,742,805.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	102,814,600.00	94,317,500.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	102,814,600.00	94,317,500.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	1,668,241,779.08	1,692,833,631.69
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,553,168,914.41	1,607,424,266.26
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,553,168,914.41	1,607,424,266.26
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,101,092,132.37	1,132,559,301.00
210101	Үндсэн цалин	726,422,894.63	847,736,982.12
210102	Нэмэгдэл	250,920,781.27	219,294,667.33
210104	Урамшуулал	102,376,083.54	65,527,651.55
210105	Гэрээт ажлын хөлс	21,372,372.93	00.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгал төлөх шимтгэл	139,612,327.05	146,152,200.00
210201	Тэтгэврийн даатгал	95,067,565.05	106,232,000.00
210202	Тэтгэмжийн даатгал	11,136,216.00	9,980,100.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	8,908,932.00	7,984,000.00
210204	Ажилгүйдлийн даатгал	2,227,283.00	1,894,200.00
210205	Эрүүл мэндийн даатгал	22,272,331.00	20,061,900.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	69,809,266.32	67,959,823.03
210301	Гэрэл, цахилгаан	10,711,175.32	14,155,647.99
210302	Түлш, халаалт	56,237,391.00	47,860,025.04
210303	Цэвэр, бохир ус	2,860,700.00	5,944,150.00
2104	Хангамж, бараа материалын зардал	46,514,395.00	19,802,452.00
210401	Бичиг хэрэг	2,206,920.00	2,005,300.00
210402	Тээвэр, шатахуун	4,779,600.00	2,294,800.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,090,000.00	1,467,500.00
210404	Ном, хэвлэл	7,101,000.00	72,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	375,000.00	426,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,785,400.00	3,556,200.00
210408	Бараа материал акталсны зардал	27,176,475.00	9,980,652.00
2105	Нормативт зардал	40,728,850.00	55,703,075.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	7,527,250.00	4,905,050.00
210502	Хоол, хүнс	32,437,100.00	48,926,925.00

Баяндэлгэр сумын ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	764,500.00	1,871,100.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	6,931,850.00	27,862,350.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	1,931,850.00	00.00
210604	Урсгал засвар	5,000,000.00	27,862,350.00
2107	Томилолт, зочны зардал	146,000.00	719,400.00
210702	Дотоод албан томилолт	146,000.00	719,400.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2,136,780.00	9,605,932.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	2,136,780.00	9,605,932.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	146,197,313.67	147,059,733.23
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	00.00	2,327,100.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	3,837,300.00	5,991,695.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	142,360,013.67	138,740,938.23
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	115,072,864.67	85,409,365.43
2132	Бусад урсгал шилжүүлэг	33,808,200.00	58,829,100.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	1,832,100.00	1,731,200.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	31,976,100.00	55,397,900.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	00.00	1,700,000.00
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	81,264,664.67	26,580,265.43
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	-111,590,518.58	-55,739,804.85

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2013 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	463,183,325.29	289,102,651.24	2,092,049,085.13	2,844,335,061.66
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	463,183,325.29	289,102,651.24	2,092,049,085.13	2,844,335,061.66
C07	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	-111,590,518.58	-111,590,518.58
C08	2014 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	463,183,325.29	289,102,651.24	1,980,458,566.55	2,732,744,543.08
D01	2015 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	463,183,325.29	289,102,651.24	1,980,458,566.55	2,732,744,543.08
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	463,183,325.29	289,102,651.24	1,980,458,566.55	2,732,744,543.08
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	-55,739,804.85	-55,739,804.85
D09	2015 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	463,183,325.29	289,102,651.24	1,924,718,761.70	2,677,004,738.23

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон		/төгрөгөөр/	
Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН	1,521,935,900.00	1,543,413,405.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,521,935,900.00	1,543,413,405.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	1,412,210,300.00	1,441,653,100.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	6,911,000.00	7,442,805.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	00.00	1,700,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	6,911,000.00	5,742,805.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	102,814,600.00	94,317,500.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	102,814,600.00	94,317,500.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	1,509,622,900.00	1,526,570,505.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,509,622,900.00	1,526,570,505.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,396,805,485.33	1,447,952,839.57
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,101,092,132.37	1,123,569,207.48
210101	Үндсэн цалин	726,422,874.63	838,746,888.60
210102	Нэмэгдэл	250,920,781.27	219,294,667.33
210104	Урамшуулал	102,376,083.54	65,527,651.55
210105	Гэрээт ажлын хөлс	21,372,392.93	00.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд шимтгэл	139,295,480.64	146,152,200.00
210201	Тэтгэврийн даатгал	94,750,718.64	106,232,000.00
210202	Тэтгэмжийн даатгал	11,136,216.00	9,980,100.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	8,908,932.00	7,984,000.00
210204	Ажилгүйдлийн даатгал	2,227,283.00	2,357,200.00
210205	Эрүүл мэндийн даатгал	22,272,331.00	19,598,900.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	69,659,472.32	63,929,980.09
210301	Гэрэл, цахилгаан	11,272,175.32	14,155,647.99
210302	Түлш, халаалт	55,526,597.00	41,860,182.10
210303	Цэвэр, бохир ус	2,860,700.00	7,914,150.00
2104	Хангамж, бараа материалын зардал	21,219,920.00	16,011,800.00
210401	Бичиг хэрэг	2,348,920.00	1,989,300.00
210402	Тээвэр, шатахуун	4,779,600.00	2,294,800.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,090,000.00	1,467,500.00
210404	Ном, хэвлэл	7,266,000.00	72,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	375,000.00	426,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	3,360,400.00	9,762,200.00
2105	Нормативт зардал	47,563,550.00	51,976,275.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	7,887,250.00	4,695,050.00
210502	Хоол, хүнс	37,751,800.00	45,410,125.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,924,500.00	1,871,100.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	11,524,850.00	29,598,350.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	6,524,850.00	00.00

Баяндэлгэр сумын ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

210604	Урсгал засвар	5,000,000.00	29,598,350.00
2107	Томилолт, зочны зардал	146,000.00	719,400.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2,466,780.00	9,605,932.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	2,466,780.00	9,605,932.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	3,837,300.00	6,389,695.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	3,837,300.00	6,389,695.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	112,817,414.67	78,617,665.43
2132	Бусад урсгал шилжүүлэг	31,552,750.00	52,037,400.00
213204	Ажил олгогчоос олгох тэтгэмж, урамшуулал	1,832,100.00	1,731,200.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	29,720,650.00	48,606,200.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	00.00	1,700,000.00
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	81,264,664.67	26,580,265.43
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	<u>12,313,000.00</u>	<u>16,842,900.00</u>
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	12,313,000.00	16,842,900.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	12,313,000.00	16,842,900.00
2200	Дотоод эх үүсвэрээр	12,313,000.00	16,842,900.00
225102	Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	12,313,000.00	16,842,900.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	<u>-12,313,000.00</u>	<u>-16,842,900.00</u>

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны		зөрүү
		Төлөвлөгөө	Гүйцэтгэл	
1				
2	НИЙТ ЗАРЛАГЫН ДҮН	1,535,970,600.00	1,509,390,334.57	26,580,265.4
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,535,970,600.00	1,509,390,334.57	26,580,265.4
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,480,326,900.00	1,459,052,934.57	21,273,965.4
2101	Цалин хөлс, нэмэгдэл урамшил	1,142,304,300.00	1,123,569,207.48	18,735,092.5
210101	Үндсэн цалин	850,049,200.00	838,746,888.60	11,302,311.4
210102	Нэмэгдэл	225,109,400.00	219,294,667.33	5,814,732.7
210104	Урамшуулал	67,145,700.00	65,527,651.55	1,618,048.5
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	146,152,200.00	146,152,200.00	0.0
210201	Тэтгэврийн даатгал	106,232,000.00	106,232,000.00	0.0
210202	Тэтгэмжийн даатгал	9,980,100.00	9,980,100.00	0.0
210203	ҮОМШӨ-ний даатгал	7,984,000.00	7,984,000.00	0.0
210204	Ажилгүйдлийн даатгал	1,996,100.00	2,357,200.00	-361,100.0
210205	Эрүүл мэндийн даатгал	19,960,000.00	19,598,900.00	361,100.0
2103	Байр ашиглах тогтмол зардал	64,717,500.00	63,929,980.09	787,519.9
210301	Гэрэл, цахилгаан	14,055,700.00	14,155,647.99	-99,948.0
210302	Түлш, халаалт	42,745,500.00	41,860,182.10	885,317.9
210303	Цэвэр, бохир ус	7,916,300.00	7,914,150.00	2,150.0
2104	Хангамж, бараа материалын зардал	16,529,700.00	16,512,700.00	17,000.0
210401	Бичиг хэрэг	1,989,300.00	1,989,300.00	0.0
210402	Тээвэр, шатахуун	2,294,800.00	2,294,800.00	0.0

Баяндэлгэр сумын ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

210403	Шуудан, холбоо, интернэттөлбөр	1,439,300.00	1,467,500.00	-28,200.0
210404	Ном, хэвлэл	575,700.00	572,900.00	2,800.0
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	431,800.00	426,000.00	5,800.0
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	9,798,800.00	9,762,200.00	36,600.0
2105	Нормативт зардал	53,228,700.00	51,520,875.00	1,707,825.0
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	4,240,300.00	4,239,650.00	650.0
210502	Хоол, хүнс	47,117,300.00	45,410,125.00	1,707,175.0
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,871,100.00	1,871,100.00	0.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	42,100,000.00	42,098,350.00	1,650.0
210601	Багаж, техник, хэрэгсэл	6,000,000.00	6,000,000.00	0.0
210602	Тавилга	6,500,000.00	6,500,000.00	0.0
210604	Урсгал засвар	29,600,000.00	29,598,350.00	1,650.0
2107	Томилолт, зочны зардал	719,700.00	719,400.00	300.0
210702	Дотоод албан томилолт	719,700.00	719,400.00	300.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	8,745,500.00	8,723,632.00	21,868.0
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр	8,745,500.00	8,723,632.00	21,868.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	5829300.00	5826590.00	2,710.0
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	5,829,300.00	5,826,590.00	2,710.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	55643700.00	50337400.00	5,306,300.0
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	00.00	00.00	0.0
2132	Бусад урсгал шилжүүлэг	55,643,700.00	50,337,400.00	5,306,300.0
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	1,731,300.00	1,731,200.00	100.0
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж	53,912,400.00	48,606,200.00	5,306,200.0
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,535,970,600.00	1,509,390,334.57	26,580,265.4
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1,441,653,100.00	1,415,862,004.48	25,791,095.5
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс	1,441,653,100.00	1,415,862,004.48	25,791,095.5
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС	94,317,500.00	93,528,330.09	789,169.9
132001	Орон нутгийн төсвөөс	94,317,500.00	93,528,330.09	789,169.9

2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	зөрүү
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл			
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН		7,442,805.0	(7,442,805.0)
21	УРСГАЛ ЗАРДАЛ		7,442,805.0	(7,442,805.0)
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ		5,742,805.0	(5,742,805.0)
2105	Нормативт зардал		455,400.0	(455,400.0)
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл		455,400.0	(455,400.0)
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж		4,724,300.0	(4,724,300.0)
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж		4,724,300.0	(4,724,300.0)
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	0.00	563,105.0	(563,105.0)
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх		563,105.0	(563,105.0)

Баяндэлгэр сумын ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	0.00	1,700,000.0	(1,700,000.0)
2132	Бусад урсгал шилжүүлэг		1,700,000.0	(1,700,000.0)
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал		1,700,000.0	(1,700,000.0)
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	0.00	7,442,805.0	(7,442,805.0)
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого		7,442,805.0	(7,442,805.0)
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилалдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		1,700,000.0	(1,700,000.0)
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		5,742,805.0	(5,742,805.0)

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Баяндэлгэр сумын ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Сүхбаатар аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор С.Ариунбаяр гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Г.Даваа, дарга, тэргүүлэх аудитор М.Нарантуяа нар тус тус хэрэгжүүлсэн.

Баяндэлгэр сумын ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Сүхбаатар аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 1 дүгээр сарын 24-ны өдрийн 05 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Бага боловсролын зорилго нь эх хэлний суурь чадамжтай, бүтээлч, сурах арга барилтай монгол хүүхэд төлөвшүүлэх, суурь боловсролын зорилго нь амьдрах ухаан, шинжлэх ухааны суурь мэдлэг, чадвар эзэмшсэн, бие даан бүтээлчээр суралцах чадамжтай иргэн төлөвшүүлэх, бүрэн дунд боловсролын зорилго нь мэдээлэл боловсруулах, шийдвэр гаргах, суралцах чадвар бүхий ирээдүйд эзэмших мэргэжлийн ерөнхий суурь чадамжтай иргэн төлөвшүүлэхэд тус тус оршино. Дээрх зорилгын хүрээнд дараах зорилтыг дэвшүүлсэн байна. Үүнд:

- Удирдлага болон багш ажилтан бүр ёс зүйн дүрмийг үйл ажиллагаандаа чанд мөрдөн ажиллана.
- Хүүхэд бүрийг тэгш хамруулах, сургах, тэдний онцлог ялгаа хэрэгцээнд суурилсан сургалт хүмүүжлийн ажлыг зохион байгуулах ;
- Сурлагын хоцрогдлыг арилгах, сургалтын чанарыг сайжруулах чиглэлээр сурагчдын математик, унших чадвар/бага/ физик, биологи, математик, англи хэл хичээлийн сурлагын чанарыг сайжруулан, ЭЕШ-ын дундаж оноог 520-д хүргэх..... гэх мэт зорилтуудыг дэвшүүлэн ажилласан байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил

Баяндэлгэр сумын ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Баяндэлгэр сумын ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2021 оны төсвийн гүйцэтгэлийн тайлангийн батлагдсан төсвийг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1.0 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны үр дүнгийн тайлангийн нийт зардал 1,691,456.3 мянган төгрөгөөс 1.0 хувиар буюу 16,914.6 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 70 хувиар буюу 11,840.2 мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Баяндэлгэр сумын ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 33,826.3 мянган төгрөгөөр буюу 1.2 хувиар буурсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/мянган төгрөг/ Өөрчлөлт
Бараа материал	95,157.3	97,540.6	2,383.3
Үндсэн хөрөнгө	2,637,587.2	2,601,377.6	(36,209.6)
Нийт хөрөнгө	2,732,744.5	2,698,918.2	(33,826.3)
Өр төлбөр		21,913.5	21,913.5
Засгийн газрын хувь оролцоо	2,732,744.5	2,677,004.7	55,739.8
Тайлант үеийн үр дүн	-	55,739.8	55,739.8
Өр төлбөр, цэвэр өмчийн дүн	2,732,744.5	2,698,918.2	(33,826.3)

Бараа материал данс: Тайлант онд төсвийн хөрөнгөөр 178,524.3 мянган төгрөгийн бараа материал худалдан, 7,992.0 мянган төгрөгийн бараа материалыг дээд шатны төсөв захирагчаас үнэ төлбөргүйгээр хүлээн авч 184,133.0 мянган төгрөгийн материалыг зарцуулсан байна.

Баяндэлгэр сумын ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Үндсэн хөрөнгө данс өмнөх оноос 36,209.6 мянган төгрөгөөр буурсан бөгөөд энэ нь 140,152.1 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийн элэгдэл бодож данснаас хасагдуулсан нь нөлөөлж байна. Тайланд онд төсвийн хөрөнгөөр 16,842.9 мянган төгрөгийн хөрөнгө худалдан авч дээд шатны төсөв захирагчаас үнэ төлбөргүйгээр 87,099.6 мянган төгрөгийн хөрөнгө хүлээн авч данс бүртгэлд тусгасан байна.

Өр төлбөр:

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 7 арга хэмжээг санхүүжүүлэхээр улсын төсвөөс 1,441,653.1 мянга, орон нутгийн төсвөөс 94,317.5 мянга, нийт 1,535,970.6 мянган төгрөгийг төлөвлөж, гүйцэтгэлээр бүрэн санхүүжсэн байна. Төсвийн гүйцэтгэлийн нийт зардлыг 1,509,390.3 мянган төгрөгөөр илэрхийлж төсвийн зарцуулагдаагүй үлдэгдэл 26,580.3 мянган төгрөгийг дээд шатны төсвийн захирагчийн дансанд төвлөрүүлсэн байна.

Төсвийн гүйцэтгэлээр гарсан нийт зардлын 1,269,721.4 мянган төгрөг буюу 84.1 хувийг цалин хөлс, ажил олгогчоос төлөх нийгмийн даатгалын шимтгэл эзэлж байгаа бол 239,668.9 мянган төгрөг буюу 15.9 хувийг байр ашиглалттай холбоотой тогтмол зардал, хангамж, бараа материалын зардал зэрэг бусад зардалд зарцуулсан байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.2 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант онд Баяндэлгэр сумын ерөнхий боловсролын сургуулийн нэмэлт санхүүжилтийн дансаар 27,442.8 мянган төгрөг төвлөрч, бүрэн зарцуулсан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Баяндэлгэр сумын ерөнхий боловсролын сургууль нь тайлант оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 3 зорилт, 21 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, 83.3 хувьтай биелсэн байна. Ковид цах тахлын улмаас хэрэгжүүлэхээр төлөвлөсөн 2 арга хэмжээг хэрэгжүүлээгүй байна.

Тус сургуульд 36 бүлэгт 1079 хүүхэд бага, суурь, бүрэн дунд боловсрол эзэмшиж байна. Үүнээс бага боловсролын хөтөлбөрт 532 хүүхэд хамрагджээ. Мөн дүйцсэн хөтөлбөр буюу зайны сургалтад 12 хүүхэд суралцаж байна.

2020-2021 оны хичээлийн жилийн ЭЕШ-аар Монгол хэл, Нийгэм судлалын хичээлээр тус бүр 1 сурагч 800 оноотой шалгагдсан бөгөөд аймгийн хэмжээнд ЭЕШ-ын дундаж оноогоор тэргүүлсэн нь тайлант оны онцлог үйл явдал болжээ.

Байгууллагын үйл ажиллагааны тасралтгүй байх зарчим, холбоотой талуудтай хийсэн ажил гүйлгээний анхаарал татсан болон санхүүгийн тайлангийн хойших үйл явдал, бусад асуудлын талаар тодорхойгүй байдал үүсээгүй байна.

3.8 Аудитын гол асуудал

Жилийн эцэст харилцах дансны хуулгыг хянаж, нягтлаагүйгээс зарим ажил гүйлгээ буцаагдаж, харилцахын үлдэгдэл дээд шатны төсөвт төвлөрч, 21,913.5 мянган төгрөгийн өр төлбөр үүссэн байна.

Материаллаг буруу тайлагналын өндөр үнэлэгдсэн эрсдэл, нөлөө бүхий эрсдэл, удирдлагын үлэмж хэмжээний шийдэл орсон асуудал, тайлант хугацаанд гарсан нөлөө бүхий ажил гүйлгээ, үйл явдал ажиглагдаагүй болно.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны цахим сайтад 119 мэдээллийг хуулийн хугацаанд нь мэдээлсэн байна. Харин цалингаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 6 зарлагын гүйлгээний 34,244.2 мянга, урсгал санхүүжилтийн 44 гүйлгээний 1,532,032.7 мянган төгрөгийн мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцэж байгаа боловч зарим мэдээллийг хангалтгүй байршуулсан гэж дүгнэлээ.

3.10 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 3,508.5 мянган төгрөгийн төлбөрийн акт, зөрчлийг арилгах 1,835.5 мянган төгрөгийн албан шаардлага хүргүүлж, санхүүгийн баримтын бүрдэлтэй холбоотой 1 зөвлөмж хүргүүлж, шийдвэрийг бүрэн хэрэгжүүлж биелэлтийг 2021 оны 72 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 59,170.2 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 16,342.0 мянган төгрөгийн зөрчилд албан шаардлага, 42,828.2 мянган төгрөгийн алдаа зөрчилд зөвлөмж өгөв.

4.1 Албан шаардлага

1. *Тайлант онд төсвийн хөрөнгөөр 16,342.0 мянган төгрөгийн машин тоног төхөөрөмж, тавилга худалдан авч төсвийн хэмнэлтийн горимыг зөрчсөн байна.*

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1¹, 41 дүгээр зүйлийн 41.2.3², Засгийн газрын 2021 оны 43³ дугаар тогтоолын 1.4⁴-т заасныг зөрчиж тохиолдсон байх, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлүүдийг хангахгүй байгаа тул албан шаардлага хүргүүлээ.

4.2 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Өр төлбөртэй холбоотой асуудал

Илрүүлэлт: жилийн эцэст харилцах дансны хуулгыг хянаагүйгээс харилцагч байгууллагад шилжүүлсэн зарим гүйлгээ буцаж, 21,913.5 мянган төгрөгийн өр төлбөр үүссэн байна.

Өгсөн зөвлөмж: Өр төлбөр үүссэн талаарх хүсэлтийг дээд шатны төсөв захирагчид хүргүүлж өр төлбөрийг барагдуулах ажлыг зохион байгуулж, ажил гүйлгээг данснаас гарсан эсэхийг тогтмол хянах.

2. Үндсэн хөрөнгөтэй холбоотой асуудал

Илрүүлэлт: Үндсэн хөрөнгийн дансанд 4,925.2 мянган төгрөгийн аж ахуйн зориулалттай материал бүртгэж, санхүүгийн тайлангийн үлдэгдлийг алдаатай илэрхийлсэн

Өгсөн зөвлөмж: Үндсэн хөрөнгө дансанд бүртгэлд аж ахуйн материалыг эрх бүхий байгууллагын зөвшөөрөл авч, эдийн засгийн ангиллын дагуу данс хооронд шилжүүлэн бүртгэх.

3. Бараа материалтай холбоотой асуудал

Илрүүлэлт: Байгууллагын үйл ажиллагаанд ашигласан 4,750.0 мянган төгрөгийн материалыг зарлага болгохгүйгээр үлдээдлээр тайлагнаж, үлдээдлийг буруу илэрхийлжээ.

Өгсөн зөвлөмж: зарцуулсан бараа материалыг анхан шатны баримтад үндэслэн данс бүртгэлээс хасаж тайланг үнэн зөв илэрхийлэх.

4. Бараа материалтай холбоотой асуудал

Илрүүлэлт: Аж ахуйн материал дансанд 11,239.5 мянган төгрөгийн сагсны самбар, волейболын тор зэргийг илүү бүртгэсэн байна.

Өгсөн зөвлөмж: Илүү бүртгээгдсэн дээрх аж ахуйн материалын учир шалтгааныг тогтоож, эрх бүхий байгууллагын шийдвэр гаргуулж, нягтлан бодох бүртгэлийн залруулга хийх.

5. Үндсэн хөрөнгөтэй холбоотой асуудал

Илрүүлэлт: Үндсэн хөрөнгийн ашиглалтын хугацааг эдийн засгийн өгөөжтэй уялдуулан зөв тогтоогоогүйгээс санхүүгийн тайланд элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн үлдэх өртөггүй 127 нэр төрлийн хөрөнгө бүртгэлтэй байгаа зөрчил нь УСНББОУС 17 Үндсэн хөрөнгийн 67 дугаар зүйлд тусгасан “Хөрөнгийн үлдэх өртөг ба ашиглалтын хугацааг наад зах нь санхүүгийн жил бүрийн эцэст хянаж үзэх ба хэрэв

¹ төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах

² төсвийн гүйцэтгэлийг хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлж, тайлагнах

³ Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай

⁴ энэ тогтоол батлагдахаас өмнө Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу зарлагдсанаас бусад автомашин, албан конторын тавилга, албаны болон ажлын дүрэмт хувцас, амралт, алжаал тайлах, фитнесийн тоног төхөөрөмж, хэрэглэлийн худалдан авалтыг зохион байгуулахгүй байх;

Баяндэлгэр сумын ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

хүлээлт нь өмнөх тооцооллоос өөр байвал уг өөрчлөлтийг УСНББОУС 3 тооцооллын өөрчлөлтийн дагуу тайлагнана" заалттай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Үндсэн хөрөнгийн эдийн засгийн нас буюу ашиглах хугацааг тухайн хөрөнгийн өгөөжтэй уялдуулан зөв тогтоож, УСНББОУС 17 Үндсэн хөрөнгийн 67 дугаар зүйлийг мөрдөж ажиллах;

6. Шилэн дансны мэдээлэлтэй холбоотой асуудал

Илрүүлэлт: Цалингаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 6 зарлагын гүйлгээний 34,244.2 мянга, урсгал санхүүжилтийн 44 гүйлгээний 1,532,032.7 мянган төгрөгийн мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн байна.

Өгсөн зөвлөмж: Шилэн дансны мэдээллийг хуульд заасан хугацаанд үнэн зөвөөр мэдээлэх

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2022 оны 6 дугаар сарын 10 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Баяндэлгэр ЕБС	5	59,170.2					1	16,342.0	4	42,828.2
	ДҮН	5	59,170.2					1	16,342.0	4	42,828.2